

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

**ГЭР БУЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙН
ХУУЛЬ ТОГГООМЖ, БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ
ЖАНЦАНДОРЖИЙН АЗЖАРГАЛЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		Эхэлсэн, дууссан хугацаа
1	2	3	4	5	6	7	

Зорилт 1.1."Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой ёсөлт, хүний хөгжлийг дэмжих"

1.1.1 Хүүхдийн эрхийн асуудлаар бодлого, хууль тогтоомжийн төсөл боловсруулна.

1.	Арга хэмжээ 1.1. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу /хууль батлагдсаны дараа/ дагалдан гарах журмыг боловсруулна. (МУХТЖҮЧ-ийн 2.3.1, 2.3.3, 2.3.5, МУЗГУАХ-ийн 2.5.8)	Журмын төсөл боловсруулалтын гүйцэтгэлийн хувь	0	90%	<p>-Монгол Улсын Их Хурлын гишүүн, Хүүхэд хамгааллын тухай хуулийн ажлын хэсгийн ахлагч Ц.Идэрбатын баталсан 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн "Ажлын дэд хэсэг байгуулах тухай" 23/03 тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж, 10 удаагийн олон нийтийн хэлэлцүүлгийг Ажлын дэд хэсэгтэй хамтран зохион байгуулж, хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулсан.</p> <p>-Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн нэгдсэн чуулганаар Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хамт өргөн мэдүүлсэн 14</p>	2024.01-12 сар	100%
----	---	--	---	-----	---	----------------	------

					<p>хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл батлагдсан.</p> <p>1. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх, мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журмын төсөл боловсруулж, батлуулахаар хянагдаж байна.</p> <p>2. Нөхцөл байдлын үнэлгээ хийх журмын төсөл боловсруулж, санал авч байна.</p> <p>3. Боловсролын сургалтын байгууллага, сүм хийдийн орчны аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээ хийх журмын төсөл, Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлагын төслийг боловсруулж, 2 удаа хэлэлцүүлж, Боловсролын яаманд 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 01/395 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>4. "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын норматив"-ын төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авч, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хуралдаанаар хэлэлцүүлэх саналтай хүргүүлэхээр бэлтгэж байна.</p>		
2.	Дэд арга хэмжээ 1.1.1. Хүүхэд хамгааллын тухай хуулийг даган гарах дүрэм, журам, стандарт боловсруулах тухай ТНБД-ын тушаал батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллана.	Гүйцэтгэлийн эзлэх хувь	0%	50%	-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны "Хүүхэд хамгааллын тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн хуулиудыг даган гарах дүрэм, журам, стандарт, аргачлал боловсруулах тухай" А/114, А/115 дугаар тушаал батлуулсан. НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн зөн Монгол ОУБ-тай уулзалт зохион байгуулж,	2024.04-12 сар	100%

				<p>дүрэм, журам, стандарт боловсруулахад шаардагдах санхүүжилтийг шийдвэрлүүлж, хамтран ажиллаж байна.</p> <p>- Дараах журам, стандартын төслийг боловсруулж, санал авах хэлэлцүүлэг зохион байгуулсан.</p> <ol style="list-style-type: none"> 1. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх, мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журмын төсөл, Нөхцөл байдлын үнэлгээ хийх журмын төсөл, Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмын төсөл, Боловсролын сургалтын байгууллага, сүм хийдийн орчны аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээ хийх журмын төслийг 4 удаа хэлэлцүүлж, Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсролын яам, Эрүүл мэндийн яам, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, хамтарсан багийн нийгмийн ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, хэлтсийн мэргэжилтэн, төрийн бус байгууллага, их, дээд сургуулийн эрдэстэн, судлаачид нийт 360 гаруй албан хаагч оролцож, санал өгсөн. 2. Хүчирхийллийн хохирогч хүүхдэд сэтгэл зүйн тусlamж үйлчилгээ үзүүлэх нийтлэг шаардлага, Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд тавих нийтлэг 	
--	--	--	--	---	--

					<p>шаардлага стандартын төсөл, Жагсаал, цуглааны үеийн хүүхэд хамгааллын стандартын төсөл, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний стандартын төсөл, Сүм, хийдийн дэргэдэх дотуур байрын стандартын төсөлд санал авах хэлэлцүүлэг 4 удаа зохион байгуулж, Стандартчилал, хэмжил зүйн газарт 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 03/414 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Стандарт, хэмжил зүйн газраас төслүүдийг хянан үзэж, 12 сарын 20-ны өдрийн Стандартын техникийн хорооны (TX46) хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж, хамтран ажиллаж байна.</p> <p>3. Хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэхэд хамтран ажиллах талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/245 дугаар албан бичгээр хүсэлт хүргүүлж, З удаагийн уулзалт зохион байгуулж, санг хөгжүүлэхэд шаардагдах дэмжлэгийг шийдвэрлүүлсэн. Энэ хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр “Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн сангийн хөгжүүлэлт” сэдэвт салбар дундын хэлэлцүүлэг зохион байгуулж, хэрэгцээ шаардлагыг танилцуулж, мэдээлэл солилцсон. Мөн Сэлэнгэ, Дархан-Уул аймагт НҮБ-ын Хүүхдийн сангийн олон улсын зөвлөх, ахлах мэргэжилтэн Мохан ажиллаж, анхан дунд шатанд</p>		
--	--	--	--	--	---	--	--

						хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох уулзалт зохион байгуулсан. Тус яамнаас холбогдох яам, агентлаг, ТЕГ, ШЕЗ, УЕПГ, YCX-оос албан бичгээр “Ажлын хэсэг”-т нэр авсан. Тушаалын төсөл хянагдаж байна.		
3.	Дэд арга хэмжээ 1.1.2. Орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмын төсөл, Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмын төслүүдийг боловсруулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	40%	Хүүхдийн хөгжил, хамгааллын салбар дундын ажлын хэсгийн хурлыг 2 удаа зохион байгуулж, Хүүхэд хамгааллын тухай хуулийг даган гарах “Орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам”, “Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам”-ын төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр ХНХ-ын дэд сайдаар батлуусан. Журмын төслийг боловсруулж, 4 удаа хэлэлцүүлэн ХЗДХЯ болон ЦХИХХЯ-руу 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 01/692, 01/693 дугаартай албан бичгээр хургэсэн. Журмын төслүүдийг дээрх яамд хянан үзэж байна.	2024.05-12 сар	100%	
4.	Арга хэмжээ 1.2. Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн орон тоог тогтоох тогтоолын төсөл боловсруулж, батлуулна.	Тийм-1 Үгүй-0	0	100%	Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан. <u>ХҮҮХДИЙН ЭРХИЙН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ОРОН ТОО ТОГТООХ ТУХАЙ</u>	2024.06-10	100%	
5.	Дэд арга хэмжээ 1.2.1. Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн орон тоог тогтоох судалгаа, зардлын тооцоо хийж, Засгийн газрын гишүүдийн саналыг нэгтгэн сайжруулна.	Гүйцэтгэлийн хувь	0	100%	- Хүүхдийн эрхийн тухай хуулийг даган гарах “Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн орон тоог тогтоох тухай”, Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Хүүхдийн эрхийн улсын байцаагчид болон салбарын байцаагчид, Хууль зүй, дотоод хэргийн	2024.06-10 сар	100%	

					яамны төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг 2 удаа зохион байгуулж, мөн яамны вебсайтад байршуулан санал авсан. Мөн Засгийн газрын гишүүдээс албан бичгээр санал авч, нэгтгэн сайжруулж, тогтоолын төслийг ГБХНХ-ын сайдын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 01/800 дугаартай албан бичгээр ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх саналтай хүргэж, батлуулсан.		
4.	Арга хэмжээ 1.3. “Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүрэм”-ийг боловсруулж, батлуулна.	Тийм-1 Үгүй-0	0%	100%	- Хүүхдийн эрхийн тухай хуулийг даган гарах “Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн ажиллах дүрэм батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, 142 дугаар тогтооюор баталсан.	2024.05-12 сар	100%
5.	Дэд арга хэмжээ 1.3.1. Хэлэлцүүлгүүд зохион байгуулж, дүрмийн төсөлд санал авч, сайжруулна.	Гүйцэтгэлийн хувь	0%	70%	“Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн ажиллах дүрэм батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулахад зөвлөх П.Баттулгатай хамтран ажилласан. Дүрмийн төсөлд санал авах хэлэлцүүлэг 3 удаа зохион байгуулж, Засгийн газрын гишүүдээс бичгээр санал авч нэгтгэн сайжруулсан.	2024.06-10 сар	100%
6.	Дэд арга хэмжээ 1.3.2. Дүрмийн төслийг эцэслэн боловсруулж, бүрдүүлбэрийн хамт Засгийн газарт хүргэхэд бэлтгэнэ.	Гүйцэтгэлийн хувь	0%	30%	Тогтоолын төслийг ГБХНХ-ын сайдын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 01/800 дугаартай албан бичгээр ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх саналтай хүргэж, батлуулсан.	2024.07-12 сар	100%

Зорилт 2. “Стратегийн зорилт 2.1: Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой ёсөлт, хүний хөгжлийг дэмжих

2.1.1 Хүүхдийн эрхийн асуудлаар хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, бодлого үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах.

	Арга хэмжээ 2.1.Хүүхэд хамгааллын тухай хууль, хамт өргөн мэдүүлж, баталсан бусад хуулийг олон нийтэд сурталчлан таниулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлийн хувь					
1.			0%	60%	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны “Хүүхэд хамгааллын тухай хууль, Нийгмийн даатгалын багц хуулийг олон нийтэд сурталчлан таниулах нэлөөллийн ажил зохион байгуулах тухай” А/40, А/67 дугаар тушаал батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.</p> <p>-Зүүн бүсийн аймгуудад 2024 оны 03 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд, баруун, хойд, говийн, төвийн болон нийслэлийн бүсүүдэд 4 сарын 16-аас 5 сарын 20-ны хугацаанд, салбарын бүх яамд, Цагдаагийн ерөнхий газар, Шүүх шинжилгээний ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Нийгмийн даатгалын ерөнхий газар, БЗД-ийн Ерөнхий боловсролын сургуулиудын Эцэг эхийн зөвлөлийн гишүүдэд 2024 оны 03-09 дүгээр сард зохион байгуулж, 6300 төрийн албан хаагч, 2800 эцэг, эхийн төлөөлөл оролцож, хууль шинэчлэлийн талаар мэдээлэлтэй болсон.</p>	2024.03.04-09 сар	100%
2.	Дэд арга хэмжээ 2.1.1. Хүүхэд хамгааллын тухай хуулийн онцлог зүйл заалтыг таниулан сурталчлах видео контент хийнэ.	Гүйцэтгэлийн хувь			<p>Хүүхэд хамгааллын тухай хуулийг олон нийтэд таниулах зорилготой З нэвтрүүлгийг “Олон нийтийн хөтөч” НҮТББ-аар гүйцэтгүүлж, 2024 оны 4 сарын 23-аас PEAK.mn, Inder зэрэг сайтууд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны фейж хуудсаар түгээсэн. Мөн хуулийн онцлог заалтыг олон нийтэд таниулах зорилгоор 6 цуврал контент хийж, олон нийтэд цахимаар түгээсэн.</p>	2024.03.04-10.01	100%

	Арга хэмжээ 2.2. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн шинэчлэх, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмж хүргүүлнэ.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	0	100%	АНУ-ын Засгийн газар болон МУ-ын Засгийн газар хоорондын "Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээний санхүүжилтээр Улсын Ерөнхий Прокурорын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, Дэлхийн зөн олон улсын байгууллага, Азийн сан, Хүйсийн тэгш эрхийн төвтэй хамтран 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүд, Хүүхдийн эрхийн улсын байцаагч 110 хүнд Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчлэл болон Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг даган гарсан шинэ журмыг танилцуулах сургалтыг зохион байгууллаа. Уг сургалтад Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчлэл, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны чиг үүрэг, Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгаалалд хууль ёсны төлөөлөгч, хүүхдийн эрхийн байцаагчийн оролцоо ба эрх зүйн зохицуулалт сэдвээр илтгэл танилцуулж, зөвлөгөө өгсөн.	2024.09-12	100%
4.	Арга хэмжээ 2.3.НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцын МУЗГ-ын 5,6 дугаар тайлант боловсруулах ажлын хэсэг байгуулна. (Хүүхдийн эрхийн тухай конвенци, НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны 5 дугаар зөвлөмжийн 49 дүгээр зүйл)	Тийм-1 Үгүй-0			НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос конвенцын хэрэгжилтийн талаарх тусгай асуумж ирээгүй, 2025 онд ирүүлэх болсонтой холбоотой хугацаа хойшилсон.		
5.	Арга хэмжээ 2.4. Хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх бодлого, үйл	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	0%	100%	Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдрийг тохиолдуулан "Амлалтаа биелүүлье. Хүүхдийн хөдөлмөрийг устгай!" уриан дор зөвлөгөөнийг 2024	2024.05-06.12	100%

	ажиллагааны хүрээнд зөвлөгөөн зохион байгуулна.				оны 06 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан. Зөвлөгөөнөөр 2023 онд зохион байгуулсан Хүүхдийн хөдөлмөрийн талаарх бодлогын зөвлөгөөний зөвлөмжийн биелэлтийг хэлэлцэж, цаашид хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар анхаарах асуудлыг тодорхойлж, нэгдсэн саналд хүрсэн. Зөвлөгөөн зохион байгуулахад Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага, Дэлхийн зөн ОУБ-ууд хамтран ажилласан бөгөөд бүх яам, ХГБХХЕГ, ЦЕГ, БЕГ, ХХҮЕГ, ХХЕГ, ГИХГ, НЭМҮТ, Европын холбоо, АНУ-ын ЭСЯ-ны төлөөллүүд, их, дээд сургууль, ТББ-ын 125 хүн оролцсон.		
--	---	--	--	--	--	--	--

Зорилт 3.Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах

3.1. Хүүхдийн эрхийг хангах асуудлаар хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх.

1.	Арга хэмжээ 3.1. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам боловсруулна. (ХХ-ын тухай хууль, ХХТ тухай хууль)	Журмын төсөл боловсруулалтын гүйцэтгэлийн хувь	0%	30%	-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны "Хүүхэд хамгааллын тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн хуулиудыг даган гарах дүрэм, журам, стандарт, аргачлал боловсруулах тухай" А/114 дүгээр тушаал батлуулсан. Мөн ХНХЯ-ны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн "Хүсэлт хүргүүлэх тухай" 11/848 дугаар албан бичгийг Дэлхийн зөн ОУБ-т хүргүүлж, 2 удаа уулзалт зохион байгуулж, санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. -“Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”-ын төслийг боловсруулж, 2 удаа хэлэлцүүлж, санал авч ажилласан.	2024.04.01-12 сар	100%
----	---	--	----	-----	--	-------------------	------

	Арга хэмжээ 3.2. АНУ-ын Засгийн газар болон МҮ-ын Засгийн газар хоорондын “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээний хэрэгжилтийг хангах, салбар дундын уялдаа холбоо, хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлийн хувь			Салбар дундын хамтарсан багийн хурал 6 удаа зохион байгуулагдаж, хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд: - Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/135 дугаар тушаалаар батлагдсан “Ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах журам”-ыг шинэчлэн боловсруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны “Журам батлах тухай” А/40 дүгээр тушаалаар баталж, Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлсэн. - Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төслийн санхүүжилтээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагуудын үйлчилгээтэй танилцаж, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмын хэрэгцээг тодорхойлох үнэлгээний удирдамж боловсруулж, Гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Азиин санд хүргүүлсэн. - Форензик ярилцлага хийх аргачлалын сургалтад аймаг, нийслэл, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, хэлтсийн 15 мэргэжилтэн, их дээд сургуулийн 2 багш хамруулж, сургагч багшаар бэлтгэсэн. Сургагч багш нараар дамжуулан 2024 оны 09 дүгээр сард 31 хүүхэд хамгааллын мэргэжилтэн бэлтгэсэн.	2024.01.05-12.	100%
2.			100%	100%			

					- АНУ-ын Засгийн газар болон МҮ-ын Засгийн газар хоорондын "Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээний 4 жилийн хэрэгжилтийн үр дүнг хэлэлцэх, уг гэрээг 1 жилээр сунгаж буйтай холбогдуулан зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэгт Төрийн нарийн бичгийн даргын хамт оролцсон.		
--	--	--	--	--	---	--	--

ТАВ."ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

5.1."ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх"

1.	Арга хэмжээ 5.1.1.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	100%	50%	-Холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн тогтоол шийдвэрийн биелэлтийн тайлан мэдээг тухай бур боловсруулж тайлагнасан. - Иргэд, олон нийтээс ирсэн өргөдөл, гомдлын хариуг холбогдох хуулийн дагуу шийдвэрлэж ажилласан.	2024.01.01-12 сар	100%
----	--	---	------	-----	--	-------------------	------

5.2.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авилгын эсрэг хууль, Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.

1.	Арга хэмжээ 5.2.1.Авилгын эсрэг хууль, Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	100%	50%	2023 оны ХОМ-ийг хуулийн хугацаанд мэдүүлж, баталгааны хуудсыг холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн. 2024 оны ХОМ-ыг 2 удаа хуулийн хугацаанд мэдүүлж, баталгааны хуудсыг холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.	2024.01.15-12 сар	100%
----	--	---	------	-----	--	-------------------	------

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур Үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	2	3	4	5	6	7	
1.	Арга хэмжээ 1. Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан байна.	Суралцсан кредит цаг	0	8 кредит цаг	Удирдлагын академийн эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, 8 кредит цагийн хичээл судалсан.	2024.03.07-06.06	100%
2.	Арга хэмжээ 2. Албадан хөдөлмөрийн асуудлаар чадавхжуулах сургалт	Суралцсан цаг	0	24 цаг	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас хамтран зохион байгуулсан сургалтад хамрагдсан.	2024.10.22-24	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хүүхдийн эрхийн хууль тогтоомж, бодлого, төлөвлөлт хариуцсан

шинжээч

(Албан тушаал)

.....*Ж.Азжаргал*/.....

(Нэр, гарын үсэг)

(Огноо)